

**ЗАВХАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Аймгийн ИТХ, Ажлын албанаас 2022 оны 05 дугаар сарын 16-20 өдрүүдэд Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул сумдын удирдамжийн дагуу сумдын ИТХ-ын ажилд хяналт- шинжилгээ үнэлгээ хийж зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, Хурлын төлөөлөгч нарт чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан.

Мөн Тэс, Тэлмэн, Тосонцэнгэл, Их-Уул сумдаар аймгийн Хурлын зарим төлөөлөгчид, Ажлын албанаас хөрөнгө оруулалтын болон ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилтай танилцан сумдын Хурлын дарга, холбогдох албан тушаалтнуудад үүрэг зөвлөгөө өгөв.

Их-Уул суманд “Төлөөлөгчийн нэг өдөр” арга хэмжээ зохион байгуулагдаж аймгийн ИТХ-ын дарга, Их-Уул сумаас сонгогдсон аймгийн Хурлын төлөөлөгч нар оролцож иргэдтэй уулзалт хийж иргэдийн дунд спортын тэмцээн зохион байгуулсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлаг “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцын чадавхыг бэхжүүлэх” төсөл аймгийн Өмнөд бүсийн сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарын чадавхыг бэхжүүлэх сургалтыг Шилүүстэй сумад зохион байгуулж сургалтад Отгон, Шилүүстэй, Цагаанхайрхан, Цагаанчулуут сумдын ИТХ-ын дарга, төлөөлөгч, нарийн бичгийн дарга нар оролцсон.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлаг “Нутгийн өөрөө удирдах байгууллагын инстстуцын чадавхыг бэхжүүлэх” төслөөр “Орон нутгийн бодлого төлөвлөлөлт ба үр дүнд суурилсан хяналтын тогтолцоо” бүсчилсэн сургалтыг аймгийн төвд зохион байгуулж Завхан, Архангай, Хөвсгөл, Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Төлөөлөгч, нарын бичгийн дарга Ажлын албаныхан хамрагдав.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд, хуулийн өөрчлөлтөд хамаарах материалын бүрдэл хангасан Алдархаан сумын иргэнд нөхөн олговорын мөнгө болох 40.0 сая төгрөгийг олгосон. Дурсгал мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу "хэлмэгдэгчдэд зориулсан ногоон төгөл" арга хэмжээний хүрээнд Завхан аймгийн Улиастай сумын төв гудамж буюу Жинст багийн нутаг Хутагтын хүрээлэнгийн талбайд

гадна хайс, хашааг засварлаж, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, сэргээх ажлыг эхлүүлээд байна.

Мөн хутагтын хүрээлэнгийн хойморт Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн гэгээн дурсгалд зориулсан дурсгалын багана босгохоор газраа сонгож ажлаа эхлүүлээд байна.

Монголын Хуульчдын Холбооны Завхан аймаг дахь салбар зохицуулагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хамтран 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр аймгийн төв талбайд “Хуульчийн Про Боно өдөр 2022” өдөрлөгийг, иргэдэд хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл өгөх, төрийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааг таниулах, сурталчлах, иргэдийн гомдол, мэдээллийг хүлээн авах зорилготойгоор зохион байгуулсан.

1.2. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 80 дугаар зарлигаар “Алдарт эх” нэгдүгээр зэргийн одонгоор 13, хоёрдугаар зэргийн одонгоор 251 эхчүүдийн шагналыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Улсын Их Хурлын гишүүд гардууллаа.



Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлөөс удирдах албан тушаалын дэс түшмэл, гүйцэтгэх албан тушаалын туслах түшмэл, дэс түшмэлийн сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулж байна.

Удирдах албан тушаалын дэс



түшмэлийн 1 ажлын байранд 3 хүн бүртгүүлснээс 2 хүн шалгалтад орж байгаа бол гүйцэтгэх албан тушаалын туслах түшмэлийн 35 ажлын байранд 30 хүн бүртгүүлснээс 19 иргэн, гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн 40 ажлын байранд 53 хүн бүртгүүлснээс 29 иргэн шалгалтад орж байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/68 дугаар захирамжаар 2022 оныг “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан тус жилийн нээлтийн үйл ажиллагаа, зүүн бүсийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөнийг Их-Уул суманд зохион байгуулсан.

Бүсийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт, зөвлөгөөний зорилго нь төрийн албан хаагчдын хууль, эрх зүйн болон ёс зүйн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, ёс зүйтэй, хариуцлагатай, манлайлагч төрийн албан хаагчийг бий болгох, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, нөхөрсөг харилцааг тогтооход оршино.

Зөвлөгөөнд Идэр, Их-Уул, Тэлмэн, Тосонцэнгэл сумдын Засаг дарга, төрийн байгууллагын дарга, эрхлэгч, захирал, төрийн захиргааны албан хаагчид зэрэг 73 албан хаагчид оролцлоо.

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр аймгийн Засаг даргын дэргэдэх зарим агентлагуудад ажиллаж, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд анхаарч ажиллах, түүнчлэн 2023 онд тохиох аймгийн түүхт 100 жилийн ойн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон тухай дурдаж, энэ хүрээнд Улиастай хотын өнгө үзэмжийг сайжруулах, байгууллага, иргэн бүр тохижилт бүтээн байгуулалтын ажилд оролцох, албан байгууллагууд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргаж даруй эхлүүлэхийг үүрэг болголоо.

Мөн БНСУ-ын хөрөнгө оруулалтаар баригдах Дулааны станцын ажил 5 дугаар сарын 21-ний өдөр нээлтээ хийж ажил нь эхлэхтэй холбоотой асуудлууд, аймгийн төв талбайг “Баян-Айраг” компани нийгмийн хариуцлагын хүрээнд шинэчлэн засварлахтай холбоотой газар доорх инженерийн шугам сүлжээг засварлах, өргөтгөх, зайлуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулж ажиллуулах, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 5 дугаар сарын 14-нд мод тарих өдрөөр хийгдэх ажлуудын бэлтгэл хангалт, малын шүлхийн вакцинжуулалтыг аймгийн хэмжээний бүх үхэр гахайд хийсэнтэй холбоотой мах, сүү, хүнсний хэрэглээ, нийлүүлэлт, хяналт, түүнчлэн

гамшиг осол, ахуйн түймрээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг зөрчил гарахаас сэргийлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах зэрэг асуудлаар аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газрын албан хаагч, мэргэжилтнүүдтэй уулзаж зөвлөмж чиглэл өгч ажиллав.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлөөс зуны эхэн сарын шинийн 9-ний билэгт сайн өдөр төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг Төрийн албаны тухай хууль, тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу зохион байгууллаа.

Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын тусгай шалгалтад тэнцэн төрийн захиргааны нэр хүндтэй, хариуцлагатай албан тушаалд шинээр томилогдон ажиллаж байгаа 12 байгууллагын 35 төрийн албан хаагч тангаргаа өргөлөө.

Тангараг өргөх ёслолын ажиллагаанд аймгийн Засаг дарга, Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь салбар зөвлөлийн гишүүд оролцлоо.

Австрали улсаас Монгол улсад суугаа Элчин сайдын яамны хэргийг түр хамаарагч Нэйл Сандерсон, 1 дүгээр нарийн бичгийн дарга Спенсер Хэйнс нар Завхан аймагт 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдөр айлчилж, аймгийн удирдлагуудтай уулзалт хийлээ. Тус уулзалтын хүрээнд дараах асуудлуудаар ярилцлаа. Үүнд:

1. Австралийн Засгийн газраас хэрэгжүүлдэг суралцангаа ажиллах, амралтаараа ажиллах тэтгэлэгт хөтөлбөрүүдэд оюутан залуусыг хамруулах;

2. Гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн бизнест дэмжлэг авах;

3. Завхан аймгийн мал аж ахуйг түшиглэн хонины үүлдэр угсааг сайжруулж, малаас гарч байгаа түүхий эд, ноос, ноолуур, арьс, ширийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгоход туршлага судалж нэвтрүүлэх;

4. Цаашид байгуулагдах жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд хамтран ажиллах;

5. Австралийн Засгийн газрын буцалтгүй тусламжийн хүрээнд бий болсон “Сарлаг брэнд”-ийг өргөжүүлэн хөгжүүлж, дэлхийн зах зээлд гаргах;

6. Байгаль орчинд тулгарч буй гамшиг, хүрээлэн буй орчны бохирдлын эрсдлийг бууруулах чиглэлд хамтарч ажиллах зэрэг асуудлуудаар ярилцаж, хамтран ажиллахаар боллоо.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

2.1.Татвар төлөлтийн байдал: Татварын орлогын төлөвлөгөө эхний 4 сард аймгийн дүнгээр 114.1 хувийн биелэлттэй, 4 тэрбум 566.2 сая төгрөгийн орлого оруулж, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 48.9 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 10.8 хувь, аж ахуйн нэгж байгууллагын албан татвар 6.6 хувь, татварын бус хүү торгуулийн орлого 6.5 хувь, авто тээврийн албан татвар 2.0 хувь, малын тоо толгойн татвар 0.7 хувь, бусад нэр төрөл 24.5 хувийг эзэлж байна. Нийт татварын орлогын бүрдүүлэлтийн 82.0 хувь буюу 3 тэрбум 742.2 сая төгрөгийг орон нутгийн орлого, 18.0 хувь буюу 824.0 сая төгрөгийг улсын төсвийн орлого бүрдүүлж байна.

Монгол банкны мэдээгээр эхний 4 сард гүйлгээнд 10 тэрбум 52.4 сая төгрөг, иргэдийн мөнгөн хадгаламжинд 70.4 мянган иргэний 104.5 тэрбум төгрөг байгаа нь иргэдийн мөнгөн хадгаламж өнгөрсөн оны мөн үеэс 11.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Аймгийн дүнгээр эхний 4 сард 156.0 тэрбум төгрөгийн зээл олгосон олгосон байна.

Гурав. Хууль зүйн бодлогын хүрээнд:

3.1. Хууль хяналтын үйл ажиллагаа: 2022 оны 5 дугаар сарын байдлаар Засаг даргын үйл ажиллагааны-35, Боловсон хүчний захирамж-1 гарсан байна. Тухайлбал: Комисс томилох тухай, Хөрөнгө гаргах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай, Захирамж хүчингүй болгох тухай, Үнэлгээний хороо байгуулах тухай, Иргэнд газар өмчлүүлэх тухай, Эрх сэргээх тухай, Зөрчил арилгуулж захирамж хүчингүй болгох тухай, Ажлаас чөлөөлөх тухай, Ажилд томилох тухай, газар эзэмших эрх шилжүүлэх тухай, эзэмших, өмчлөх эрх олгох тухай, Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай, Урамшуулал олгох тухай, Эрх шилжүүлэн гүйцэтгүүлэх тухай гэх мэт захирамж гаргасан.

Соёлын ажилтны зөвлөгөөн, Статистикийн хэлтэсийн нийт-56 албан хаагчдад Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Мөн Зүүн бүсийн төрийн албан хаагчдийг чадавхжуулах бүсийн сургалтад тус хэлтсийн Архивын тасгийн дарга Ш.Даваадэмбэрэл, мэргэжилтэн Э.Гомбодорж нар оролцож тус тусын чиглэлээр сургалт мэдээлэл өгч ажиллаа.

Монголын Хуульчдын холбооноос жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийг “Хуульчийн Про боно” өдөр болгон тэмдэглэж ирсэн бөгөөд энэ өдөрлөгийн хүрээнд Монголын Хуульчдын Холбооны Завхан аймаг дахь салбар зохицуулагч, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, аймгийн Гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр аймгийн төв талбайд “Хуульчийн Про Боно өдөр 2022” өдөрлөгийг, иргэдэд хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл өгөх, төрийн байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагааг таниулах, сурталчлах, иргэдийн гомдол, мэдээллийг хүлээн авах зорилготойгоор зохион байгууллаа.

Өдөрлөгийн арга хэмжээний үеэр аймгийн Прокурорын газраас “Хүүхэд бүрийн төлөө” аяныг өрнүүлж Улиастай сумын Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдын дунд “Цахим-Индэр” АХА тэмцээнийг зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу тус хэлтсийн хамт олон харьяа хэлтэс агентлаг болох аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлыг газрын үйл ажиллагаатай газар дээр танилцан зөвлөмж, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

“Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Боловсрол шинжлэх ухааны газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран сургуулийн өмнөх насны хүүхдүүд, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох дадал хэвшил олгох, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль дүрмийн мэдлэгийг олгох, түгээх, сурталчлах зорилготойгоор 2022 оны 05 дугаар арын 07-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Тэмцээний нээлтэд аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Ц.Улам-Оргих, аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, Улиастай сумын засаг дарга Ч.Наранбат нар оролцсон ба тэмцээнд 9 цэцэрлэгийн 108 хүүхэд, эцэг эх, багш нарын хамтаар хурд хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдөж, шилдгүүдээ тодрууллаа.

3.2. Гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл: Аймгийн хэмжээгээр 82 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 32 хувийг иргэдийн эрх чөлөө эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 43.9 хувь нь бусдын өмчлөлийн эсрэг гэмт хэрэг, 24.1 хувийг бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна.

Оны эхнээс өссөн дүнгээр 4438 зөрчил илрүүлж, 147 хүн эрүүлжигдэн, 44 хүн баривчлагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс зөрчил 389-р, гэмт хэргийн улмаас гэмтсэн хүн 1, учирсан хохирол сая төгрөг 226.8 өсч, эрүүлжигдсэн хүн 33, баривчлагдсан хүн 15-р тус тус буурсан байна. Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 44.4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1.6 пунктээр буурсан байна.

3.3.Архивын ажлын мэдээлэл:Төрийн архивын баримтыг мэдээллийн технологит шилжүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2 хөмрөг, 3 данс, 44 хадгаламжийн нэгжийн 3856 хуудас баримтыг сканердан, photoshop програмд

засварлаж, 2 хөмрөг, 3 дансны 44 хадгаламжийн нэгж, 3856 хуудас баримтыг цахим хэлбэрт оруулж, 44 PDF холболт хийлээ.

265 иргэн, 12 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 608 баримт шүүж, 149 хуулбар, 191 лавлагаа, тодорхойлолт олгож төрийн үйлчилгээ үзүүлээ.

E-archives үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан Үндэсний төв архив, аймаг нийслэлийн архивуудаас ирүүлсэн 11 хүсэлтийг хүлээн авч, 9 иргэний лавлагааг шийдвэрлэн илгээсэн.

3 хөмрөг үүсгэгчээс 610 хадгаламжийн нэгж баримтыг хүлээн авч Төрийн архивын сан хөмрөгт баяжилт хийлээ.

Тосонцэнгэл, Их-Уул сумдын удирдлагууд төрийн алба хаагчид, архив бичиг хэргийн ажилтнуудад Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журам стандартын чиглэлээр сургалт хийж 218 ажилтан алба хаагчдыг хамруулсан.

Тосонцэнгэл, Их-Уул сумдын Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагуудад хяналт шинжилгээ үнэлгээ хийж зөвлөн туслах ажлын хэсэгт ажиллаж дээрх сумдын Засаг даргын Тамгын газар болон төрийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, цаашид авах арга хэмжээний талаар заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

3.4.Онцгой байдал: Монгол Улсын Шадар сайдын 2022 онд Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг Удирдах албан тушаалтны сургалтыг 1 удаа, 5 цаг 23 хүн, Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан ажилтны сургалт 5 удаа 20 цагийн багтаамжтай 162 хүн, Их дээд сургууль, МСҮТ-ийн оюутан сурагчдын сургалт 2 удаа 8 цагийн багтаамжтай 104 оюутанд зохион байгууллаа.

Мөн Улиастай сумын Товцог, Өлзийт, Богдын гол, Жинст, Жаргалант, Чигэстэй багуудад айл өрхүүдэд пийшин, зуух, яндангийн аюулгүй байдлын стандарт, норм, нормативыг мөрдүүлэх, галын аюулгүй ажиллагааны заавар таниулах зорилгоор “Аюулгүй галлагаа” 2 дугаар аяныг 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Айл өрхүүдийн пийшин зуухны бүрэн байдлыг үнэлэх эрсдэлийн үнэлгээний хуудсыг ашиглан Улиастай сумын 6 багийн 5110 өрхийн 8719 иргэнд пийшин зуухны стандартыг мөрдөх, эвдрэл гэмтэлтэй пийшин зуух хэрэглэхгүй байх, үнс нурмаа зориулалтын ухсан нүх болон таглаатай төмөр саванд хийж хэвших, хог хаягдлыг

ангиллаж хаях, яндангийн залгааг гэр байшингийн дээврээс 70 см дээш байх, гэр байшингаа 5 метрээс багагүй зайд барих, зуухны амны хэсэгт 50 х 70 харьцаатай оч үсрэхээс сэргийлсэн үл шатах дэвсгэрийг байрлуулах, бага насны хүүхдийг гэр орон байранд нь цоожлох болон бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх талаар заавар зөвлөмж өгч, гарын авлага боршур материал 600 ширхгийг тараасан.

Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төвийн нийт 26-н багш ажилчдад хүүхдийг болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээл орж, “Сурагчийн аюулгүй байдалд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд хамтран ажиллах талаар төлөвлөгөөг танилцуулан мэдээ мэдээлэл хүргэн ажилласан.

“Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье”, Зөвийг хэвшүүлье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтрах сурагчдын аюулгүй байдал, эцэг эх, асран хамгаалагчийн оролцооны талаар арга хэмжээ зохион байгуулсан ба 355 өрхийн 2646 иргэн хамрагдсан.

Улиастай сумын 2, 3, 5, 8 дугаар цэцэрлэгүүд дээр гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийлээ. Үнэлгээний ажлын хэсэгт цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, ажилчдын төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, гамшгийн эрсдэл, гамшиг, аюулт үзэгдэл эмзэг байдал, чадавхын талаар мөн тахимын хичээлийг орсон. **Аргачлалын** дагуу тухайн цэцэрлэгт тохиолдож болох аюулын төрөл бүр дээр аюулын түвшин, зэрэг, эмзэг байдал, өртөнги, чадавхыг үнэлж эрсдэлийн үнэлгээний матрицын аргаар эрсдэлийн түвшинг тодорхойлсон.

Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийг индексийн аргаар тодорхойлохдоо аюул, эмзэг байдал, өртөх байдал, чадавхын үнэлгээнд харгалзах үзүүлэлтүүдэд I,II,III индекст харгалзах (1-3) оноог өгч үнэлсэн.

05 дугаар сарын үнэлгээний нэгдсэн дундаж дүн 4,2 буюу дундаж эрсдэлтэй үнэлэгдсэн. Аймгийн 3 сум бага эрсдэлтэй бусад 21 сум дунд эрсдэлтэй байна.

Гал түймрийн хяналт шалгалтаар Монгол Улсын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын баталсан удирдамжуудын хүрээнд “Давшваажил” ХХК-ний шингэрүүлсэн хий түгээх 3 станц, гэр хорооллын **1430** айл өрх, Шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сүм хийд, цуглаан номлолын нийт 8 газарт, галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, норматив, баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 01, 2022 оны 5 дугаар сарын 1-ээс 15, 2022 оны 5 дугаар сарын 9-өөс 15-ны хүртэлх өдрүүдэд зохион байгуулан ажиллалаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Улиастай, Тосонцэнгэл сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт 21 шатахуун түгээх станцуудад төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллалаа.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс ирүүлсэн ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах албан хүсэлтийн дагуу 22 газарт хяналт шалгалт зохион явуулж зохих шийдвэрийг гаргасан.

Хяналт шалгалтаар нийт 3 байгууллагын 21 зөрчил, гэр хорооллын 1430 айл өрх, Шашны сүм хийд цуглаан номлолын нийт 8 газарт 1310 зөрчил илрүүлж газар дээр нь 307 зөрчлийг арилгуулсан ба бусад зөрчил дутагдлуудыг арилгуулахаар заавал биелүүлэх албан шаардлага 9, мэдэгдэл 1 хүргүүлж тус аж ахуй нэгж байгууллага, айл өрхийн нийт 6600 иргэнд Галын аюулгүй байдлын тухай хуулинд заагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх үүрэг, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон шалгалтаар илэрч байгаа зөрчлүүдийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн.

ОБЕГ-ын Шуурхай удирдлага зарлан мэдээлэх төвийн Холбоо зарлан мэдээлэл хариуцсан оператортай утсан холбоогоор 80 удаа, Онцгой байдлын ерөнхий газар болон хил залгаа Увс, Баян-Өлгий аймгуудтай радио станцаар 120 удаа, цахим шуудангаар 248 удаа, цахим дүрст холболтоор 116 удаа холбоонд орж, холбооны чанар байдал болон техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцсон.

Объектын гал түймрийн зөрчлийн дуудлага 2 удаа ирсэн ба бусад аюул, ослын дуудлага ирээгүй байна. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал аймгийн хэмжээнд сүүлийн 24 цагт шинээр 5 тохиолдол батлагдаж нийт батлагдсан тохиолдол 17346, 23 иргэн нас барч, 17312 иргэн эмчлэгдэн эдгэрсэн байна. Улсын эмнэлэгт 2, гэрээр эмчлэгдэж байгаа 9 иргэн байна.

Аймгийн хэмжээнд ногоон бүс болсон-22, идэвхгүй-0, идэвхтэй-2 сум байна. Дархлаажуулалтад хамрагдвал зохих иргэдийн 1-р тун-89.1%, 2-р тун-86,4%, 3-р тун-60,7%, 4-р тун-14,1% хувийн хамрагдалтай байна.

Малын гоц халдварт шүлхий өвчин 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 22 сумын 28 багийн 881 өрхийн нийт 77,139 өвчилж, 73,738 малын шинж тэмдэг арилсан. Устгасан 70 байна.

Хорио цээрийн дэглэмд Дөрвөлжин, Их-Уул, Тэс, Цагаанхайрхан зэрэг 4 сум байна. Хязгаарлалтын дэглэмд Алдархаан, Сонгино, Тэлмэн, Баянтэс, Яруу, Тосонцэнгэл зэрэг 6 сум байна.

24 сумын 116 багийн 12866 өрхийн 245200 толгой үхэр, 144 толгой гахайг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулахаар 64 ажлын хэсэг гарган ажиллаж ажлын хэсэг удирдах ажилтан 64, малын эмч 68, санитарч, техникч 22, туслах ажилтан, мал баригч 137, жолооч 56, нийт 347 хүн үүрэг гүйцэтгэж дархлаажуулалт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

4.1. Боловсрол, соёлын чиглэлээр: Улсын төрөлжсөн олимпиадын хоёрын давааг Улиастай сумын ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургууль дээр 9 судлагдахуун, 36 төрлөөр зохион байгуулж, давхардсан тоогоор 1002 суралцагч хамрагдаж, судлагдахуун бүрээр эхний 3 байрыг шалгаруулж, улсын төрөлжсөн олимпиадын III давааны олимпиадад оролцох, багш суралцагчийг шагнаж урамшуулахад 3,5 сая төгрөг зарцууллаа.

Монгол туургатны “МИНИЙ МОНГОЛ БИЧИГ” олон улсын YI уралдаанд “ШИЛДГИЙН ШИЛДЭГ”-ээр Улиастай сумын ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн Монгол хэл, бичгийн багш Д.Юнрэндорж, Улсын төрөлжсөн олимпиадын III даваанд ГАЗАРЗҮЙН хичээлийн 12-р ангийн ангилалд Улиастай сумын ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн суралцагч Онолтын Шанхүү, түүхийн XXIV олимпиадын III даваанд ТҮҮХИЙН хичээлийн 12 дугаар ангийн ангилалд Их-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн суралцагч Б. Бямбажаргал нар хоёрдугаар байранд шалгарч, “МӨНГӨН МЕДАЛЬ” хүртлээ.

Монгол бичгийн тэргүүний уншигч шалгаруулах улсын XV уралдааны 3-ын даваанд Сантмаргаз сумын ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн сурагч Л. Наранчимэг III байрт, Сонгино сумын ерөнхий боловсролын сургуулийн 9-р ангийн суралцагч П.Оюунхорол, Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын II сургуулийн 12 дугаар ангийн суралцагч Б.Өлзийдэлгэр нар тусгай байр эзэлсэн байна. Мөн Оросын холбооны Буриад улсад зохион байгуулагдсан “НАЙДАЛ – 2022” олон улсын өсвөрийн хөгжимчдийн VI уралдаанд СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежийн оюутан, суралцагчид амжилт үзүүлж оролцлоо.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Завхан аймагт ажиллаж Улиастай сумын боловсролын салбарын багш, ажилтнуудтай уулзалт хийж, Боловсролын шинэчлэлийн бодлого, яамнаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, Төсөв, хөрөнгө оруулалт, боловсролын байгууллагын санхүүжилтийн шинэчлэлийн талаар мэдээлэл хийлээ. Мөн ажил үйлсээрээ шалгарсан 10 багшийг боловсролын тэргүүний ажилтан, [Боловсрол, шинжлэх ухааны яамны жуух бичгээр](#) шагнаж, Монгол улсын Зөвлөх багшийн шалгуур хангасан 8 багшийн үнэмлэхийг гардуулж өглөө.

УИХ-ын гишүүд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн Улиастай сумын IV цэцэрлэгийн барилгын дээврийн засвар, 5 сургуулийн байгалийн ухааны кабинет, морин хуурын тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 2023 оны төсвийн төсөлд ЕБС-ийн ширээ сандлын хөрөнгө оруулалтыг тусган ажиллахаар шийдвэрлэж, орон нутгийн мэргэжлийн сургуулийг хөгжүүлэхэд түлхүү анхаарч ажиллана гэдгээ хэллээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог нэмэгдүүлэхэд удирдлага, арга зүйгээр ханган ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, багш суралцагчдыг хөгжүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааны зардалд орон нутгийн төсвөөс 15,0 сая төгрөгийг дэмжлэг үзүүлж, 21 сумын ерөнхий боловсролын сургуулийн 497 суралцагчдад зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, 916 цагийн сургалтыг зохион байгуулахад давхардсан тоогоор 19 ментор багш ажиллаж, 162 багш, удирдах ажилтан хамтран ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийн хэмжээст оноог ахиулах зорилгоор сургуулийн сургалтын менежер, хичээл заагч багш нар, БШУГ-ын мэргэжилтнүүд хамтран сар бүрийн сүүлчийн долоо хоногт сорилго шалгалт авч, нэгтгэн анализ, дүгнэлт хийн ажиллаж байна. 4 дүгээр сарын шалгалтад 2160 шалгуулагч шалгагдаж, гүйцэтгэлийн дундаж хувь 53.69 буюу өмнөх сараас 1.3 хувь өссөн бөгөөд 5 дугаар сарын сорилго шалгалтын нэгдсэн дүн 6 дугаар сарын эхний 7 хоногт гарна.

2022 оны ЭЕШ-ын журмын 1 дүгээр зүйлийн 1.5, 1.6 дахь заалтыг үндэслэн 2022.04.02-ны өдрийн шалгалтад хамрагдаж чадаагүй болон босго онооны болзол хангаагүй шалгуулагчид дахин 2022 оны 5 дугаар сарын 07-ны өдөр шалгалтад хамрагдаж, 205 шалгуулагч бүртгүүлснээс 157 шалгуулагч орж, 76.5 хувь нь хамрагдсан байна.

Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргалын санаачилгаар Улиастай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчид, багш, удирдах ажилтан, эцэг, эх асран хамгаалагч нартай “Мэргэжил бүхэн сайхан” уулзалт зохион байгуулж,

Улиастай сумын ерөнхий боловсролын сургуулийн 327 суралцагч, эцэг, эхийн 50 төлөөлөл, анги удирдсан багш, сургуулийн захирал, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүдийн төлөөлөл 400 гаруй иргэд оролцлоо.

Уулзалтын үр дүнд аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд зарцуулах 24.8 сая төгрөгийг 12 жилийн сургуультай сум бүрийн ахмад багш нарын зөвлөх үйлчилгээнд зориулан ажиллахаар шийдвэрлэлээ.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, суралцагчдыг “Үдийн хоол” үйлчилгээнд шат дараатай хамруулах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Завханмандал, Отгон, Эрдэнэхайрхан, Сонгино сумын ерөнхий боловсролын сургууль, Нөмрөг, Улиастай сумын VI цэцэрлэгт хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд нэн шаардлагатай байгаа I, II хоолны тогоо, цахилгаан жигнүүр, цахилгаан пийшин, аяга таваг ариутгагч зэрэг 120,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр шийдвэрлэн хүлээлгэж өглөө.

Хүүхэд хамгааллын хамтарсан багийг чадавхжуулах, зөвлөн туслах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, 5 бүсэд ажиллаж, Ерөнхий боловсролын сургуулийн “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ”, “Дотуур байрны орчин, үйлчилгээнд” Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчдаар эрсдлийн үнэлгээ хийлгэлээ. Эрсдлийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг хагас жилээр тайлагнах тухай сумдын Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлээд байна.

Аймгийн Цагдаагийн Газраас санаачлан аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Боловсрол шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран хүүхэд багачууд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд зөв боловсон оролцох дадал хэвшил олгох, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль дүрмийн мэдлэгийг олгох, түгээх, сурталчлах зорилгоор Улиастай сумын цэцэрлэгүүдийн дунд **“ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ЦАГААН ТОЛГОЙ-2022”** уралдаант тэмцээнийг зохион байгуулж, цэцэрлэгийн 72 хүүхэд, эцэг эх, багш нийт 150 гаруй хүн оролцлоо.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, хамтран Канад Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Монгол улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд **“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ”** сургалтыг Төрийн албаны зөвлөл, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын

ерөнхий газар, “Төрийн албан хаагчийн зарчимч, шударга байдлыг бэхжүүлэх нь” дэд төсөлтэй хамтран цахимаар зохион байгуулж, сургалтад ерөнхий боловсролын 29, мэргэжлийн боловсролын 2 сургуулийн ёс зүйн зөвлөлийн 154 гишүүн оролцлоо.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 09- ний өдрийн А/96 дугаар тушаал, 2021 оны А/07 дугаар тушаал, боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2022 оны 01/217 дугаартай “Гүйцэтгэлийн үнэлгээ зохион байгуулах удирдамж”-ийн дагуу ерөнхий боловсролын 29 сургуулийн үндсэн багш нарын ажлын гүйцэтгэл, үр дүнг суралцагчийн сурах үйл ажиллагааны үр дүнгийн ахицыг тодорхойлох бичгийн шалгалтыг хуваарийн дагуу авч гүйцэтгэлээ. Мөн багшийн ажлын үр дүнг суралцагчийн хөгжил, хамгаалал, төлөвшил, багшийн мэргэжлийн хөгжил, сургууль болон олон нийтийн үйл ажиллагаанд оруулсан хувь нэмэр зэрэг шалгуурыг суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж, багшийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний асуулгын хэлбэрээр үнэллээ.

Бичгийн шалгалтыг БҮТ-өөс гаргасан хуваарийн дагуу орон даяар нэгэн зэрэг хамгийн ихдээ нэг сургууль дээр 144, хамгийн багадаа 14 шалгалтыг тус тус зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын ивээл дор аймгийн соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, 23 сумын соёлын төв, Хөгжимт жүжгийн театр, Төв номын сан, аймгийн музей, СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллеж, Соёл, урлагийн газар, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, Утга зохиолын нэгдэл, МУЭ-ийн Завхан салбар, “Боролдой” номын өргөө зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын 55 гаруй удирдах ажилтнууд оролцлоо.

Зөвлөгөөний үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нөөц сангаас 3,5 сая төгрөгийн дэмлэг үзүүллээ.

Зөвлөгөөний хүрээнд “Соёл, урлагийн салбарын өнөөгийн байдал, цаашдын зорилт”, “орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа зорилт, арга хэмжээ”, “2022 оны төсвийн онцлог, хэрэгжилт”, “Төсвийн хөрөнгө оруулалтын 2022 оны хэрэгжилт, 2023 оны төлөвлөлт”, “Төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал”, “Хөдөлмөрийн тухай шинэчилсэн хуулийн найруулга”, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ” сэдвээр илтгэл тавигдаж, аймгийн соёл урлагийн хөгжлийн стратеги (2022-2025) төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, улс орны үнэт зүйл, өв соёлыг хадгалах, хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар дараах уриалгыг гаргаж соёл, урлагийн байгууллагуудад хүргэхээр шийдвэрлэлээ.

Хүүхэд залуучуудад Монгол өв соёлоо өвлүүлэх, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, тэдэнд урлаг гоо зүйн боловсрол олгох, төлөвшүүлэх зорилгоор 2022 оны А/197 дугаар захирамжаар хүүхдийн урлаг, соёлын “Яргуй-2022” наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, төсвийг баталж, наадмыг зохион байгууллаа. Тус наадамд аймгийн ерөнхий боловсролын сургууль, төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх клубын 800 гаруй суралцагчид доорх 5 төрлөөр оролцлоо.

- 1.Монгол ардын дуу (ардын богино дуу, уртын дуу, харилцаа дуу)
- 2.Монгол ардын бүжиг (гоцлол болон хамтлаг)
- 3.Монгол ардын хөгжим (гоцлол болон хамтлаг)
- 4.Ардын язгуур урлаг (ардын аман зохиол, ерөөл, магтаал)
- 5.Монголын уламжлалт шагайн наадгай (хасаа харваа, шагай шүүрэх)

Наадмыг шүүх шүүгчдыг аймгийн Засаг даргын 2022 оны А/266 дугаар захирамжаар томилж, хариуцлагын гэрээ хийж, Хөгжимт жүжгийн театр, Соёл урлагийн Их сургуулийн салбар Хөгжим бүжгийн коллежийн багш нар ажиллалаа. “Яргуй-2022” наадмын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 5,0 сая төгрөг зарцууллаа.

Аймгийн музейн сан хөмрөгт хадгалагддаг дүрслэх урлагийн шилдэг бүтээлүүд болох Монгол Улсын Ардын зураач (МУАЗ) н.Одон, МУАЗ, Ж.Түмбаяр, МУАЗ Б.Дашдорж, МУАЗ Г.Батзориг тэргүүтэй 9 зураачийн түүхэн зураг, хөрөг зураг болон бурханы зураг зэрэг 63 үзмэр, эд өлгийн зүйл, Халтарын Билэгжаргалын нэрэмжит Соёл Урлагийн Их Сургуулийн салбар Завхан дахь Хөгжим бүжгийн коллежийн уран зургийн ангийн багш, суралцагчдын 20 гаруй бүтээл, Завхан аймгийн Зураач, урчуудын холбооны 26 бүтээл нийт 109 бүтээлээр аймгийн музейн байгалийн танхимд түр үзэсгэлэн гаргаж 2022 оны 05 дугаар сарын 11-нээс 17-ны өдрүүдэд нийт 372 үзэгч үйлчлүүлсэн байна.

Үндэсний бичиг соёл, номын баярын арга хэмжээг энэ жил УИХ-ын дарга Г.Занданшатарын ивээл дор "Илүү их уншъя" уриатайгаар тэмдэглэн өнгөрүүллээ.

Нээлтийн үйл ажиллагаанд номын сангийн уншигчид, багш сурган хүмүүжүүлэгчид оролцсон бөгөөд номын баярын арга хэмжээний хүрээнд хуучинномын солилцоо худалдаа, “Үлгэрийн баатрууд амилсан нь” дүрийн тоглолт, “Боролдой” номын дэлгүүрийн хямдралтай номын худалдаа, “Түүх өгүүлсэн түүх” гэрэл зургийн үзэсгэлэн, “Босоо бичигтэн” монгол бичгийн уран бичлэгийн үзэсгэлэн зэрэг үйл ажиллагаанууд зохион байгуулагдлаа.

4.2.Эрүүл мэнд, спортын чиглэлээр: Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулах улсын төсвийг Эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэн. Энэ чиглэлийн мэдлэг ойлголтыг өгөх, чадавхжуулах сургалтыг аймгийн ИТХ, аймгийн удирдлагууд, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагуудын төлөөлөл 40 хүнийг оролцуулан 2022 оны 05 дугаар сарын 15-наас 19-ны өдрүүдэд 4 өдөр зохион байгууллаа. Сургалт нь “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” 3843-MON, 3844-MON (COL), “Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг сайжруулах” ТА 9701 төслүүдийн хүрээнд “Стратегийн худалдан авалтын тогтолцоог бэхжүүлэх, Эрүүл мэндийн салбарын санхүүгийн менежментийн чадавхийг бэхжүүлэх” чиглэлийн дагуу явагдсан. Энэхүү сургалтыг 20-23 өдрүүдэд Тосонцэнгэлийн Нэгдсэн эмнэлгийн 25 эмч, албан хаагчийг оролцуулан зохион байгуулсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн мэс заслын тасгийг улсын төсвийн 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бөөр шээсний доод замын дурангийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Үүний үр дүнд: аймгийн Нэгдсэн эмнэлэгт түрүү булчирхайн хавдар, шээсний сүвийн нарийсал, давсагны хавдар, давсагны чулуу, мөн шээсний сувагт стент гуурс тавих зэрэг 10 гаруй хагалгааг хийх боломжтой болж байна.

Энэхүү мэс заслыг орон нутагт нутагшуулах арга зүйн удирдлагаар хангах ажлыг УКТЭ-н урологийн мэс заслын эмч анагаах ухааны доктор Д.Баян-Өндөр эмчээр ахлуулсан баг ирж 3 өдөр хагалгаа хийж ажилласан.

Цаашдаа орон нутагт бөөр шээсний доод замын мэс заслын эмчилгээ хийх боломжтой болсон бөгөөд мэргэжлийн эмч, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан төдийгүй эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлыг тодорхой түвшинд шийдэх боломж бүрдсэн байна.

“Эрүүл мэндийн салбарын үйлчлүүлэгчийн нэг өдөр” арга хэмжээг Улиастай сумын түвшинд Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлдэх төвийн спорт зааланд зохион байгуулж, Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Уламжлалт анагаах ухааны төв, Одчимнаран хувийн эмнэлэг, эм ханган нийлүүлэх байгууллага эмийн сан нийт 17 байгууллагын 150 гаруй албан хаагч үйл ажиллагаагаа сурталчилж, иргэдэд газар дээр нь үйлчилгээг хүргэж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд эрт илрүүлэг, үзлэгийг зохион байгуулах нээлтийн үйл ажиллагааг 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр сумын түвшинд, аймгийн Нэгдсэн эмнэлэг дээр нэгэн зэрэг хийж, иргэдэд мэдээллийг өргөн хүрээнд хүргэж ажиллалаа.

0-17 насны багцийн үзлэгийг 22 сумын Эрүүл мэндийн төв, хөдөөгийн Нэгдсэн эмнэлэг 1, Өрхийн эрүүл мэндийн 3 төвд зохион байгуулж байна. 18-30 насны багцын үзлэгийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, Одчим Наран эмнэлэгт, 31- дээш насны багцын үзлэгийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Одчим Наран эмнэлэгт тус тус зохион байгуулж байна.

2022 оны 05 сарын 30-ны өдрийн байдлаар 0-5 насны 1248, 6-17 насны 2846 хүүхэд, 18-с дээш насны 640 иргэн хамрагдаж цахим програмд мэдээллийг оруулаад байна.

Завхан аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо хамтран уул уурхайн ажилчдын дунд сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, үзлэг шинжилгээ зохион байгуулах гурвалсан гэрээг байгуулж гэрээний хэрэгжилтийн хрээнд Дөрвөлжин сумын Цогт багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Баян айраг эксплоерейшн ХХК-ны 261 ажилчдыг үзлэгт хамруулан, шаардлагатай иргэдээс цэрний шинжилгээ хийж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан байна.

НҮБ-н Хүүхдийн сангийн дэмжлэгээр хэрэгжиж буй "Хүүхдэд ээлтэй орон нутаг" дэд хөтөлбөрийн хүрээнд "Өсвөрийн үе тэнгийн сургагч хүүхэд" бэлтгэх сургалтыг 20 суманд зохион байгуулж 6-11 дүгээр ангийн сурагчид, дотуур байрын багш, сумын эрүүл мэндийн төвийн эх баригч бага эмч, сургуулийн эмч, эрүүл мэндийн багш нийт 275 хүнийг хамруулсан байна. Өсвөр насны хүүхдүүдэд эрүүл мэндийн зөв мэдлэг, мэдээллийг түгээх, зөв хандлага дадлыг хэвшүүлэх, үе тэнгийхэн бие биедээ нөлөөллийг ажил хийж хүүхдүүдээс сургагч багш бэлдсэн нь хүүхдүүд өөр хоорондоо суралцах боломжийг бүрдүүлсэн нь сургалтын гол үр дүн байлаа.

Биеийн тамир, спортын салбар: Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар хэрэгжүүлсэн "Илүүдэл жингүй-Эртэч монгол" аяны үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж, хаалтыг 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улиастай сумын нутаг дэвсгэр далайн төвшнөөс дээш 2400 м өндөр "Товцог хайрхан"-нд алхалт хийснээр өндөрлүүлээ.

Хаалтын үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж 52 байгууллагын 780 гаруй албан хаагч, иргэд оролцсон. "Товцог хайрхан"-ны оройд 2 төрлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж, аянд нэгдэн амжилттай оролцсон

төрийн төрийн бус 6 байгууллагыг Биеийн тамир, спортын улсын хорооны шагналаар шагнаж урамшууллаа.

Аяны үр дүнд “Илүүдэл жингүй -Эртэч монгол” аяны хугацаанд нийтийг хамарсан биеийн тамир спортын арга хэмжээ, спортын уралдаан тэмцээн, дугуйн аялал, алхалт, уулын аялал, бүжиг, фитнэсс, клубүүдийн үйл ажиллагаа, сум байгууллагын төвшин дэх арга хэмжээ зэрэг 50 гаруй үйл ажиллагаанд давхардсан тоогоор 50139 иргэн хамрагдсан мэдээ байна.

Аймгийн Засаг даргын санаачилгаар “Хөдөлгөөн-эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлж Amka-dancer, Амар –амьдрал ТББ, Индра ТББ –ууд нь бүжиг, иог, дасгал хөдөлгөөний сургалтыг явуулж 24 суманд 2-3 спорт бүжгийн сургагч багш бэлдснээс гадна бий биелэгээ, шугаман бүжгийг хийж хэвшүүлэн төрийн байгууллага бүр бүжгийн хамтлагтай болсон байна. Сум бүр өглөөний дасгалыг, 500 гаруй иргэн тогтмол уулын болон дугуйн аялалд явж байна. Улиастай сумын Цогт Фитнесс төвтэй Биеийн тамир, спортын газар хамтран илүүдэл жинтэй иргэдийн дунд уралдаан зарлан дүгнэж хамгийн өндөр жингээ хассан 4 иргэнийг урамшууллаа.

Бүх ард түмний XV наадмын сагсан бөмбөгийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн Завхан аймгийн “Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлдэх төв”-ийн зааланд 2022 оны 05 дугаар сарын 9 нөөс-11-ний өдрүүдэд амжилтай зохион байгуулагдлаа.

Тэмцээнд Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан аймгийн шилдэг 10 багийн 120 гаруй баг тамирчид оролцлоо.

Нийгмийн даатгал, халамж

Аймгийн хэмжээгээр нийгмийн даатгалын сангаас эхний 4 сард 12.9 мянган хүнд 27.0 тэр бум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож, 7.3 тэр бум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Эхний 4 сард 23435 хүн нийгмийн даатгалд хамрагдсанаас 3261 иргэн буюу 13.9 хувь нь сайн дурын даатгалд хамрагдсан байна.

Сангуудаар авч үзвэл: Тэтгэврийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 0.2 хувиар, ҮОМШӨ сангийн орлогын төлөвлөгөө 14.8 хувиар, ажилгүйдлийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 47.6 хувиар тасарч, тэтгэмжийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 5.2 хувиар, тасарсан байна.

Тэтгэвэрийн сангийн зарлага 26392.6 сая төгрөгт, Тэтгэмжийн сангийн зарлага 527.0 сая төгрөг, ҮОМШӨ-ний зарлага 33.9 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалийн сангаас 89.8 сая төгрөг тус тус зарцуулж нийт 27043.3 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, даатгалыг олгосон байна.

Халамжийн сангийн сангийн үйл ажиллагааны эхний 4 сарын мэдээгээр Халамжийн тэтгэвэр 1506 хүнд 1760.8 сая төгрөг, нөхцөлд мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт 22363 хүнд 2496.2 сая төгрөг нийт 23869 хүнд 4257.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг үзүүлсэн байна.

Хөдөлмөр эрхлэлт

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1189 болж, өнгөрсөн оны мөн үеэс 97.2 хувиар буюу 586 хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 540 эмэгтэй ажил идэвхитэй хайж байгаа нь ажилгүйчүүдийн 45.4 хувийг эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 9.0 хувь нь 15-24 нас, 32.4 хувь нь 25-34 нас, 28.4 хувь нь 35-44 нас, 24.7 хувь нь 45-54 нас, 3.7 хувь нь 55-59 нас, 1.8 хувь нь 60 дээш насны ажилгүйчүүд байна.

Ажилгүйчүүдийн 1.3 хувь нь боловсролгүй, 3.1 хувь нь бага, 7.1 хувь нь суурь, 56.8 хувь нь бүрэн дунд, 4.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 3.0 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 23.7 хувь нь дээд боловсролтой хүмүүс тус тус эзэлж байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд: Аймгийн хэмжээнд 5 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны 1519.3 мянган хээлтэгч малын 1091.4 мянга (71.3%) нь төллөжээ. Гүүний 28.8 хувь, үнээний 38.3 хувь, ингэний 35.4 хувь, эм хонины 77.8 хувь, эм ямааны 74.8 хувь нь төллөж байна. Гарсан төлийн 98.8 хувь буюу 1078.8 мянган төл бойжиж байна. Төл бойжилтын хувь өмнөх оны мөн үеэс 1.0 пунктээр өссөн байна.

Тариалалтын явцын мэдээг сумдаас долоо хоног бүрийн даваа, пүрэв гарагуудад авч нэгтгэн ХХААХҮЯаманд мэдээлж байна. Тариалалтын явцын мэдээгээр үр тариа 800 га, малын тэжээл 50 га, төмс 41 га, хүнсний ногоо 30.3 га-д тариалалт хийгээд байна.

ХХААХҮЯамнаас хөнгөлөлттэй үнээр нийлүүлсэн 1500 кг төл сонгины үр, Гала сортын 2000 кг төмсний үрийг татан авч 13 сумд олгох хуваарь хийж олгож ХААТасгаар дамжуулан өрхийн тариалан эрхлэгчдэд олгох арга хэмжээг зохион байгууллаа.

Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор арилжааны банкаар дамжуулан олгож байгаа жилийн 3 хувийн хүүтэй, 2 жилийн хугацаатай зээлд 17 иргэн хамрагдаж 245.0 сая төгрөгийн зээл авсан байна.

Стратегийн хүнсний нөөцийн мэдээг <http://foodsupply.mofa.gov.mn/index> программ ашиглан 7 хоног бүр 24 сумаас авч нэгтгэн ХХААХҮ-н яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн баталгаажуулалтын зөвлөлийн 2 удаагийн хуралд хуваарийн дагуу оролцон тохирлын гэрчилгээ шинээр авах, сунгах хүсэлт өгсөн 9 сумын 23 иргэн аж ахуйн нэгжид хийсэн үнэлгээтэй танилцан санал орууллаа.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон 2019, 2020 оны зээлд 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Завхан аймгийн Төрийн аудитын газрын аудитор Оюунжаргалын хамт 6 ААН, 1 иргэний зээлд хяналт шалгалт хийж зээлийн эргэн төлөлт, үйл ажиллагааны явцтай танилцсан.

ХХААХҮЯам, ЖДҮГазар, Францын элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан “ХАА-н хоршоодын хөгжил” сэдвээр цахим туршлага солилцох уулзалтад Улиастай, Дөрвөлжин, Их-Уул, Нөмрөг сумын хоршоодын төлөөллийг хамруулсан.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

6.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Аймгийн “Аялал жуулчлалын нэгдсэн зөвлөгөөн”-ийг БОАЖЯ, АЗДТГ, БОАЖГ, АЖХ, best хөтөлбөр хамтран 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Тосонцэнгэл сумын Хожуулын гол жуулчны баазад, амжилттай зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд БОАЖС-ын зөвлөх Г.Галбадрах, БОАЖЯ-ны мэргэжилтэн Б.Одбаяр, Аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал, ИТХ-ын дарга Ц.Улам-Оргих, АЗДТГ-ын дарга Г.Мягмарсүрэн, ХБТХОХ-ийн дарга Д.Азжаргал, БОАЖГ-ын дарга Б.Мөнхбат, Аймгийн АЖХ-ны тэргүүн З.Нарантуяа, АЖХ-ны дарга Б.Жавхлан, нар оролцон 24 сумын Засаг дарга нар холбогдох төрийн байгууллагууд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын төлөөлөл нийт 100 гаруй оролцогчид оролцлоо.

БОАЖЯ-наас Төрөөс аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилт, Жишиг отоглох цэгийн талаар танилцуулсан бол Аймгийн аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал танилцуулгыг АЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга Д.Азжаргал аймгийн аялал жуулчлалын холбооны үйл ажиллагаа хэрэгжүүлж буй ажил Улаагчны хар нуурын ТЭЗҮ төслийн талаах танилцуулга мэдээллийг АЖХ-ны тэргүүн З.Нарантуяа танилцуулсан.

Мөн Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудлуудын талаар нээлттэй хэлэлцүүлэг явуулсан. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмж нь Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг дээшлүүлэх, жуулчдад зориулсан бренд бүтээгдэхүүн үйлчилгээг гарган, жуулчдын аюулгүй аялах нөхцөл боломжоор хангах,

эвент арга хэмжээ зохион байгуулах зэрэг цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлсон.

Зөвлөгөөний үеэр “Завханд Үйлдвэрлэв” аймгийн бренд бүтээгдэхүүнүүдийн үзэсгэлэн худалдааг гаргасан бөгөөд Улиастай сумын 1 дүгээр сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш н. Урангоо уран бичлэгийн гайхамшигийг үзэсгэлэнгийн үер оролцогчдод газар дээр нь шууд бичин үзүүлсэн.

Завхан нутгаар Зөв аялъя уриалгад зөвлөгөөнд оролцогчид нэгдлээ.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд зөвлөгөөнд оролцогчид мод тарилаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Завхан аймгийн 24 суманд мод сөөг тарих ажлыг зохион байгууллаа. Үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын мод тарих ажлын нээлтийг 2022.05.14-16-ны өдрүүдэд Улиастай, Тосонцэнгэл сумдад зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн талбайд мод сөөг тарьж “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-д нэгдэхийг уриаллаа. Нээлтийн арга хэмжээнд оролцсон иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мод тарих арга аргачлалын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гарын авлага материал тараалаа. Мод тарих өдрөөр 24 сумын иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагууд өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн талбайд 81000 ширхэг мод, сөөг тарилаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэн бүр хашаандаа мод, бут, сөөг тарьж ургуулах, амьдарч буй орчныхоо ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, эзэмшил газрынхаа өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн ая тухтай, эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, цаашлаад хүүхэд багачууд болон хүн бүр мод тарих ажилд гар бие оролцох боломжийг бий болгох, мод бут, цэцэг тарих, арчлан хамгаалах түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэхийг сурталчлах зорилгоор “Хашаандаа мод тарья” болзолт уралдаан аяныг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын санаачилгаар тарьц, суулгацын нөөцийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд 24 сум, 18 мод үржүүлгийн газруудад иж бүрэн усалгааны систем бүхий ХҮЛЭМЖ, 4300 ширхэг суулгацын дэмжлэг үзүүллээ.

Ногоон төгөл ногоон паспорт цэцэрлэгт хүрээлэнд Улиастай сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 8 Шатахуун түгээх станц, 6 Усан халаалтын зуух нийт 12 аж ахуйн нэгжээр нийгмийн хариуцлагын хүрээнд 3500 ширхэг мод тариулах ажлыг зохион байгууллаа.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 сургагч багш бэлтгэх сургалтанд 24 сумын 72 сургагч багшийг хамрууллаа.

Мод үржүүлгийн газарт 0.7 га талбайн хөрс боловсруулж ногоон мөчирөөр 25000 ширхэг улиас, бургасны суулгац, 1000 ширхэг үхрийн нүд, 1500 ширхэг шинэсний тарьц, нохойн хошууны 250 ширхэг суулгац, тэхийн шээг 1000 ширхэг нийт 30000 орчим тарьц суулгац тарьж суулгах ажил гүйцэтгэж байна.

Тарьц суулгац тарих ажилд аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтарч 10 иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллалаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг хаврын “Бүх нийтийн хаврын их цэвэрлэгээ”-г аймгийн хэмжээнд зохион байгуулж нийт 2561 га талбайгаас 996 тонн хог хаягдал цуглуулж, цэвэрлэсэний 380га талбайн 200 тн хог хаягдлыг улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу газраас, 630 га талбайн 146 тн хог хаягдлыг голын ай сав дагуу газраас, 1551 га талбайн 650 тн хог хаягдлыг бусад газраас цэвэрлэж, 8,855,481 төгрөгийг зарцуулсан дүнтэй байна. Нийт 349 аж ахуйн нэгж, албан байгууллагын 3445 гаруй алба хаагчид, 3030 иргэдийн оролцоотойгоор бүх нийтийн хаврын их цэвэрлэгээг зохион байгуулсан байна. Мөн 332 малын сэг зэм, 800 бүртгэлгүй буюу золбин нохой, муурыг устгасан бөгөөд 7384 нүхэн жорлонгийн 45436,148 м² талбайг ариутгасан байна.

Ахуйн хортон шавьж мэрэгч устгал, халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар Ариусгал ХХК-ний, Монклийн ХХК-ний ариутгал халдваргүйтгэлийн бодисын үндсэн үйлчлэгч, халдваргүйжүүлэгч уусмалын хлорын идэвхи, халдваргүйжүүлэлтийн зэрэгт үнэлгээ өгөх зорилгоор Франц улсад үйлдвэрлэсэн жавелион нэрийн бодис болон 0,06% -ийн найруулсан уусмал, жилью халдваргүйтгэлийн бодисоос 7 дээж авч МХГазрын нэгдсэн лабораторид хими, нян судлалын шинжилгээнд хамруулсан. Улиастай суманд:

Багийн нэр	Нүхэн жорлонгийн	Бохирын цооногын	БЦ орчмын талбай
------------	------------------	------------------	------------------

	тоо	тоо НЖ,	
Жаргалант	575	365	3450
Чигэстэй	475	475	2850
Жинст	200	145	1205
Өлзийт	300	200	1799
Богдын гол	1193	518	7155
Довцог	400	280	2399
Нийт	3143	1822	18858

Аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран “БАЙГАЛИА ХАМГААЛЪЯ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Байгаль орчны багц хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор удирдамж боловсруулан 24 сумын ЗДТГ-т хүргүүлэн ажилласан.

6.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 4 сарын байдлаар оны үнээр 9 тэрбум 876.2 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 28.1 хувиар буюу 2 тэр бум 163.8 сая төгрөгөөр өсч, нийт үйлдвэрлэлээс ААНэгжийн үйлдвэрлэл нь 8 тэр бум 964.5 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 911.7 сая төгрөг болсон байна. Үйлдвэрлэлд цахилгаан, дулаан, усан хангамжийн үйлдвэрлэл 53.3 хувийг, хүнсний үйлдвэрлэл 17.6 хувь, хувцас үйлдвэрлэл 4.4 хувь, модон эдлэл үйлдвэрлэл 1.4 хувь, арьс ширэн эдлэл үйлдвэрлэл 1.9 хувь, өлөн гэдэс үйлдвэрлэл 0.8 хувь, эсгий эдлэл үйлдвэрлэл 0.6 хувь, бусад үйлдвэрлэл 20.0 хувийг тус тус эзэлж байна.

6.3. Дэд бүтцийн чиглэлээр: Сум суурин газрын суурьшлын бүс буюу эдэлбэр газрын хил заагийг шинэчлэн тогтоох ажлыг 3 сумын хэмжээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.1. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд одоогийн сум, тосгон, суурин газрын суурьшлийн бүсийн хил заагийг ерөнхийлөн тодорхойлсон бөгөөд эдгээр хил зааг нь газар дээрээ суурьшил үүсэхэд боломжтой эсэх, ямар нэг хориглолт, хязгаарлалтын бүсэд орж байгаа эсэх, өмчлүүлсэн болон өмчлүүлэхээр төлөвлөсөн байршлыг хамарч байгаа эсэх, байгалийн сөрөг нөлөө байгаа эсэх (намаг элсний нүүлт, хад асга), хог хаягдал, тариалан, ашигт малтмалын талбай гэх мэт давхардал байгаа эсэхийг шалгах

1.2. Мөн аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг батлагдсан баримт бичгүүдэд заасан хил заагтай тулган шалгах хот байгуулалтын норм дүрэмд заасан 1 хүнд ногдох талбайтай уялдуулан тооцох

1.3.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хүчтэй болон дунд зэрэг элэгдэлд орсон тариалангийн талбайн хамгаалалтын ойн зурвас байгуулах байршлыг тогтоох судалгааг дараах байдлаар хийж, зурган файл болон тайлбарын хамт ирүүлнэ.

1.4.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд улсын хэмжээнд хүчтэй болон дунд зэрэг салхины элэгдэл орсон тариалангийн талбайн зураглалыг гаргасан бөгөөд эдгээр талбайд одоо хамгаалалтын ойн зурвас байгаа эсэх , байгаа бол солбицол, байршил, цаашид хамгаалалтын ойн зурвас байгуулах боломжтой байршил, салхины чиглэл, давтамж, усалгааны болон хөрсний нөхцөл зэрэг мэдээллийг оруулах

Газрын кадастрын мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг 24 сумд зохион байгуулж одоогийн байдлаар 78 хувийн гүйцэтгэлтэй байна.

д/д	сумын нэр	ЛМ код	Нийт нэгж талбар	2022.02.25	нөхөн бүрдүүлсэн нэгж талбар
1	Алдархаан	lm_8104	1273	1429	156
2	Асгат	lm_8107	338	338	0
3	Баянхайрхан	lm_8113	450	482	32
4	Баянтэс	lm_8110	597	605	8
5	Дөрвөлжин	lm_8116	455	455	0
6	Завханмандал	lm_8119	411	446	35
7	Идэр	lm_8122	507	554	47
8	Их-уул	lm_8125	1086	1103	17
9	Нөмрөг	lm_8128	807	851	44
10	Отгон	lm_8131	690	712	22
11	Сантмаргаз	lm_8134	558	561	3
12	Сонгино	lm_8137	490	496	6
13	Түдэвтэй	lm_8143	788	794	6
14	Тэлмэн	lm_8146	516	757	241
15	Тэс	lm_8149	752	771	19
16	Тосонцэнгэл	lm_8140	3569	3592	23
17	Ургамал	lm_8152	648	653	5
18	Улиастай	lm_8101	5823	5901	78
19	Цагаанхайрхан	lm_8155	371	426	55
20	Цагаанчулуут	lm_8158	430	441	11
21	Цэцэн-Уул	lm_8161	357	357	0
22	Шилүүстэй	lm_8164	290	297	7
23	Эрдэнэхайрхан	lm_8167	361	423	62
24	Яруу	lm_8170	388	390	2
	Нийт		21955	22834	879

Улиастай сумын Дулааны цахилгаан станцын шав тавих ёслолын үйл ажиллагаа 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр болж УИХ гишүүн Ц.Цэрэнпунцаг,

Б.Баярсайхан, Засгийн газрын гишүүн Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Завхан аймгийн ИТХ-ын дарга Ц.Улам-оргих, Завхан аймгийн Засаг дарга Д.Түвшинжаргал Бьюксан инженеринг ХК-ийн захирал Чой сан зэрэг албаны хүмүүс, ард иргэд оролцлоо.

Дулааны станцын гүйцэтгэгч Мон энерги корпораци, зураг төслийн зохиогч Мон энерги консалтинг ХХК, 10 аймгийн дулааны станцын нэгжийн төлөөллүүд 2022 оны 05 дугаар 19-21 өдрүүдэд газар дээр нь ажиллаж дулааны станцын 1-р хэлхээний трассыг эцэслэн сонгосон.

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/57 тоот захирамжаар байгуулагдсан ажлыг хэсэг Гудамж төслийн ажлын чанар байдалд үнэлэлт дүгнэлт өгөхөөр 2022 оны 05 дугаар сарын 16-18-ний өдрүүдэд газар дээр нь ажиллаж дүгнэлт гарах ажил хийгдэж байна.

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР